



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/218

Арвайхээр


Тусгай зөвшөөрөл олгох тухай

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.4, 11.2.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.10.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хархорин сумын нутаг Сайр-1 талбайд Баяннайман ХХК-д, "Сайр-3" талбайд "Дагинас" ХХК-д түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар шинээр олгосугай.

2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгжийн хайгуулын талбайд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө, оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Т.Ариунболд), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Хархорин сумын Засаг дарга (Л.Энхбат) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100475